

## ХОНЬ, ЯМААНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Цэцэг өвчин нь өндөр халуурал, арьс, салст бүрхүүлд цэврүүт гүвдрүү үүсэх, дотоод эрхтний үрэвсэлийн шинжээр илэрдэг цочмог халдварт өвчин юм.

Үүсгэгч: Поксвирусын язгуурын Каприпокс төрлийн үүсгэгчээр үүсгэгдэнэ. Хонь, ямааны цэцэг өвчний үүсгэгч нь ийлдэсийн нэг хэвшилтэй, бусад төрлийн амьтдыг өвчлүүлдэггүй. Уг вирус нь тоосгон, гонзгой дөрвөлжин буюу зууван хэлбэртэй, ДНХ агуулсан, 300X270X200 нм хэмжээтэй байдаг.

Тэсвэрт чанар: Цэцэг өвчний үүсгэгч бусад вирусыг бодвол гадаад орчин, малын биемахбод, түүхий эдэд удаан хугацаагаар идэвхээ хадгалдаг. Тухайлбал: 2-4<sup>0</sup>С-д 2 жил хүртэл, өвчилж эдгэрсэн малын бие дэхь хуурай тав хогжруу, тунгалагийн булчирхайд -5-10<sup>0</sup>С-д 4-5 жилийн турш халдварлах чанараа алдахгүй, өвчилж эдгэрсэн малын үс ноосонд 2 сар хүртэл, гадаад орчинд 2-6 сарын турш идэвхээ алдахгүй. Харин 1 хувийн карболийн хүчлийн уусмалд хэдхэн минутад идэвхээ алдана.

Халдвар дамжин тархах: Халдварын эх үүсвэр нь өвчилсөн болон нууц үедээ байгаа хонь, ямаа бөгөөд тэдгээрийн нус, нулимас, баас, шээс, шарх, тавны хогжруу зэргээр гадаад орчныг бохирдуулна. Мөн өвчтэй мал, амьтныг гардан эмчлэх, тэжээх явцад хувцас, малын тоног хэрэгсэл, ноос, ноолуур, арьс, вирусээр бохирлогдсон хашаа, хороо, тэжээл, хэвтэр, бууцаар дамжин халдвар тархана. Цэцэг өвчнөөр хонь ямаа нас, хүйс, үүлдэр харгалзахгүй өвчлөх ба өсвөр болон эрлийз мал илүү мэдрэмтгий байдаг. нас гүйцсэн малын өвчлөл, үхэл хорогдол өсвөр малынхаас харьцангуй бага байдаг.

Эмнэл зүйн шинж тэмдэг: Өвчний нууц үе 21 хүртэл хоног байна. Цэцэг өвчнөөр өвчилж буй хонь ямааны биеийн халуун 41<sup>0</sup>С хүрч 1-5 өдрийн турш үргэлжилнэ. Нүд, ам, хамраас нулимас, салст идээт нус, нуух гоожих, зовхи хавагнах, судасны лугшилт олширох, амьсгал түргсэх, цэврүүт гүвдрүү, булдруу ихэвчлэн толгой, уруул, хамрын самсаа, шанаа, нүдний орчим болон цавь, суга, дэлэн, хуухнаг, гуя, сүүлний дотор талын үсгүй хэсэгт гарч, ус, тэжээлд дургүй болох шинж тэмдэг илэрнэ. Булдруу нь эхлээд бага зэрэг хавагнасан ягаан өнгөтэй, дугуй хэлбэртэй тууралт байх ба 1-2 хоногийн дараа улаан хүрээтэй, хатуу гүвдрүү болно. Хэмжээний хувьд амархан томрох бөгөөд энэ үед малын халуун нэмэгдэнэ. 1-3 хоногийн дараа гүвдрүү тунгалаг, шаравтар өнгөтэй шингэнтэй болно. Гүвдрүүний өнгөн хөрс нимгэн тав 5-6 хоноод хуурна. Өвчилсөн хонь, ямааны нуруун дээр дарахад маш эмзэглэлтэй байна. Өвчин хүндэсэн үед тууралт, гүвдрүүнүүд хоорондоо нийлж арьсыг ихээхэн хэмжээгээр гэмтээдэг ба идээт үрэвсэл болж хавсарна. Гүвдрүү орчмын арьс үхжиж ярьшаад эдгэрэхдээ сорви үлдээнэ. Үүнийг Монголчууд хар цэцэг гэж нэрлэдэг ба ихэвчлэн хурга, ишигэнд тохиолдоно.

Хоёрдогч халдаваар хүндэрвэл үхлийн хувь өндөр байна. Хээлтэй мал өвчилсөн үед халдвар ихэсээр дамжин хээл хаях, үхсэн төл гарах шинж илэрнэ. Өвчний эмнэл зүйн шинж

тэмдэг хөнгөх хэлбэрээр илэрвэл үхэл, хорогдол 5-10 хувиас хэтрэхгүй ба өвчний шинж тэмдэг богнин хугацаанд олон малд илрэх үед вирусын хоруу чанар ихсэж өвчилсөн хонь, ямаа олноор хорогдохоос гадна 4 сараас доош төлийг үхэл 100 хувь хүрч болно.

Тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- 1.Хорио цээр тогтоож холбогдох арга хэмжээ авах,
2. Өвчний ил шинж тэмдэгтэй малыг ялгаж тусгаарлах, устгах,
3. Вакцинжуулах арга хэмжээ авах,
4. Малын хашаа хороо, өтөг бууц, тоног хэрэгсэлийг халдваргүйжүүлэх,
5. Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох зэрэг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

Малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад дараахи зөвлөмжийг өгч байна.

Малдаа ямар нэг өвчний шинж тэмдэг илэрсэн үед харъяа сум, дүүрэг, багийн мал эмнэлгийн байгууллагт яаралтай мэдэгдэх, дуудлага өгөх,

Өвчний шинж тэмдэгтэй малыг ялгаж тусгаарлах, бэлчээрт явуулахгүй байх,

Малаа хоньчлон хариулах, өөр айлын малтай нийлүүлэхгүй байх,

Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох, /худалдан борлуулах, отор нүүдэл хийх гэх мэт/

Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хот, сууриас гаргахгүй байх зэрэг арга хэмжээг өвчний онош тогтоож оношлогдох хүртэл авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХЯНАЛТЫН ГАЗАР